



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум,  
7-р баг, Жинст 0, Утас/Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 258

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ШАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГАД**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн танай сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын тайлан, дүгнэлт, шийдвэрийг хүргүүллээ.

Аудитын шийдвэрийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, хариу ирүүлнэ үү.

Хавсралт... хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

07030643



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Говь Алтай аймгийн Шарга сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГАА-2022/10/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр
Алтай хот	Утас: 70483413 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>
2022 он	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор: Д.Цэрэнханд
	Утас: 70484030 Цахим хаяг: <a href="mailto:tserenkhandd@audit.gov.mn">tserenkhandd@audit.gov.mn</a>

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/ .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/ .....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/ .....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/ ...	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/ .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/ .....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1. Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	12
3.5.1 Орлогын данс .....	13
3.5.2 Зардлын данс .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18

## Товчилсон үгийн жагсаалт

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлсэн сан



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022. 03. 25 № 188

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Тонхил сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шарга сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07020522

ШАРГА СУМЫН ЗАСАГ  
ДАРГА С.СҮХБААТАР  
ТАНАА



## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>485,149.30</b>	<b>726,167.40</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>98,430.40</b>	<b>141,775.20</b>
33	АВЛАГА	185,732.70	373,019.60
35	БАРАА МАТЕРИАЛ	200,986.20	211,372.70
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,758,523.10</b>	<b>3,707,243.50</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,758,523.10	3,707,243.50
39200	Биет хөрөнгө	3,704,932.10	3,648,701.00
39300	Биет бус хөрөнгө	53,591.00	58,542.50
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,243,672.40</b>	<b>4,433,410.90</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,621.30	30,725.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,621.30	30,725.80
41300	Өглөг	4,621.30	30,725.80
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,239,051.10</b>	<b>4,402,685.20</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>4,239,051.10</b>	<b>4,402,685.20</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,316,579.20	1,316,579.20
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,910,253.10</b>	<b>2,073,887.20</b>
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,012,218.80	1,012,218.80
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,243,672.40</b>	<b>4,433,410.90</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,042,128.2</b>	<b>3,249,418.6</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>57,525.9</b>	<b>54,345.4</b>
110	Орлогын албан татвар	50,384.6	44,482.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	50,384.6	44,482.8
113	Хөрөнгийн албан татвар	2,070.0	1,918.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	5,071.3	7,944.5
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,611,973.5</b>	<b>348,667.8</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,611,973.5	348,667.8
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,372,628.8</b>	<b>2,846,405.4</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,603,985.3</b>	<b>3,015,931.4</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,603,985.3</b>	<b>3,015,931.4</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,942,422.2	2,315,967.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,212,387.6	1,268,124.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,288.9	165,896.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,554.7	104,382.0
2104	Хангамж, бараа материалын зардал	63,644.6	75,670.3
2105	Нормативт зардал	62,088.5	276,645.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,260.0	49,992.1
2107	Томилолт, зочны зардал	5,210.2	3,940.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,656.7	29,340.8

Говь Алтай аймгийн Шарга сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	299,330.9	341,975.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	661,563.0	699,963.9
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	1,438,142.9	233,487.2
V	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	99,201.8	69,853.1
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	1,338,941.1	163,634.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,517,677.0</b>	<b>2,812,679.0</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>57,525.9</b>	<b>54,345.4</b>
110	Орлогын албан татвар	50,384.6	44,482.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	50,384.6	44,482.8
113	Хөрөнгийн албан татвар	2,070.0	1,918.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	5,071.3	7,944.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,862.4	6,477.2
1181	Газрын төлбөр	696.4	1,010.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	512.4	456.6
1183	Бусад татвар	0.0	0.0
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>76,622.3</b>	<b>112,684.2</b>
120	Нийтлэг татварын бус орлого	76,622.3	112,684.2
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	2,383,528.8	2,645,649.4
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,313,890.8	2,564,758.0
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,313,890.8	2,564,758.0
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,640,807.7	1,860,794.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,209,551.0	1,270,517.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,288.9	165,896.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	108,897.3	82,774.8
2104	Хангамж, бараа материалын зардал	55,090.2	69,363.5
2105	Нормативт зардал	44,559.5	115,894.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,249.7	55,467.5
2107	Томилолт, зочны зардал	5,210.2	3,940.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,924.2	30,321.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,036.7	66,618.0
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	673,083.0	703,963.9
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>203,786.2</b>	<b>247,920.9</b>
IV	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	0.0	0.0
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	147,508.6	124,476.1
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	147,508.6	124,476.1
2200	Дотоод эх үүсвэрээр	147,508.6	124,476.1
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	-147,508.6	-124,476.1

Говь Алтай аймгийн Шарга сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	-61,350.0	-80,100.0
14	Бусад эх үүсвэр	0.0	0.0
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	61,350.0	80,100.0
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.0	0.0
25	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-5,072.4</b>	<b>43,344.8</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	103,502.7	98,430.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	98,430.4	141,775.2

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/**

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,903,065.3	2,903,065.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,955.3	-2,955.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,900,110.0	2,900,110.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	1,338,941.1	1,338,941.1
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,239,051.1	4,239,051.1
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,239,051.1	4,239,051.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0
<b>13</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>4,239,051.1</b>	<b>4,239,051.1</b>
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	163,634.0	163,634.0
<b>20</b>	<b>2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>4,402,685.2</b>	<b>4,402,685.2</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/**

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,997,912.10	1,915,272.44
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,818,772.30	1,765,319.29
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,793,803.60	1,744,505.32
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,258,444.30	1,238,538.32
210101	Үндсэн цалин	945,215.10	933,248.78
210102	Нэмэгдэл	120,480.00	119,270.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,600.00	11,866.00
210104	Урамшуулал	74,113.00	72,996.64
210105	Гэрээт ажлын хөлс	106,036.20	101,155.90
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	169,038.00	162,346.32
210201	Тэтгэврийн даатгал	114,975.40	111,445.99
210202	Тэтгэмжийн даатгал	14,020.80	12,701.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,764.20	10,389.36
210204	Ажилгүйдлийн даатгал	2,672.00	2,524.89
210205	Эрүүл мэндийн даатгал	26,605.60	25,284.52
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	85,116.20	82,774.82
210301	Гэрэл, цахилгаан	15,850.00	14,042.32
210302	Түлш, халаалт	64,566.20	64,142.00
210303	Цэвэр, бохир ус	4,700.00	4,590.50
210304	Байрны түрээс	0.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	56,665.50	53,402.03
210401	Бичиг хэрэг	7,325.10	7,159.37
210402	Тээвэр, шатахуун	34,697.20	34,256.46
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,500.00	3,661.70
210404	Ном, хэвлэл	383.60	341.90
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,756.90	1,413.40
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,002.70	6,569.20
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	81,348.00	76,402.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,150.30	22,139.23
210502	Хоол, хүнс	53,927.70	49,066.97
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,270.00	5,196.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	82,249.40	75,228.70
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,158.90	23,475.00
210602	Тавилга	6,733.50	6,733.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	880.00	871.00
210604	Урсгал засвар	44,477.00	44,149.70
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,368.10	3,104.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	5,368.10	3,104.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,990.40	7,621.93
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,922.40	3,653.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	998.00	648.00
210803	Даатгалын үйлчилгээ	600.00	600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	190.00	85.19

**Говь Алтай аймгийн Шарга сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	140.00	60.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000.00	700.00
210807	Газрын төлбөр	90.00	31.95
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	550.00	501.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500.00	1,342.50
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>45,583.70</b>	<b>45,087.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,333.70	42,318.25
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,250.00	2,768.75
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,968.70</b>	<b>20,813.98</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,968.70</b>	<b>20,813.98</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,008.70	11,585.70
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,960.00	9,228.28
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>97,439.80</b>	<b>69,853.15</b>
223001	Бусад хөрөнгө	97,439.80	69,853.15
224001	Стратегийн нөөц хөрөнгө	0.00	0.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>81,700.00</b>	<b>80,100.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	81,700.00	80,100.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,997,912.10</b>	<b>1,961,564.43</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,183,228.20</b>	<b>1,160,821.52</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	0.00
310002	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	0.00	0.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,183,228.20	1,160,821.52
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	0.00	0.00
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>697,930.60</b>	<b>686,418.16</b>
320001	Орон нутгийн төсвөөс	614,490.80	602,978.36
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	83,439.80	83,439.80
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>19,453.30</b>	<b>8,456.23</b>
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0.00	0.00
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,453.30	8,456.23
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>97,300.00</b>	<b>105,868.53</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,200.00	315.23
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	73,100.00	105,553.29
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	21,000.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	25,387.47
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	71,679.45

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/**

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>205,651,797.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>205,651,797.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>170,911,797.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>31,979,503.00</b>
210101	Үндсэн цалин	21,027,164.00
210104	Урамшуулал	6,353,595.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,598,744.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>3,549,822.50</b>
210201	Тэтгэврийн даатгал	3,549,822.50
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,961,460.00</b>
210401	Бичиг хэрэг	1,704,020.00
210402	Тээвэр, шатахуун	10,597,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,000.00
210404	Ном, хэвлэл	918,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,735,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>39,492,292.50</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	34,792,492.50
210502	Хоол, хүнс	3,999,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,289,819.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00
210602	Тавилга	189,819.00
210604	Урсгал засвар	4,100,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>836,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	836,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>42,699,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,699,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>22,103,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,800,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,303,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,740,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>34,740,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,740,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>213,573,077.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>213,573,077.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	33,650,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,677,477.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,878,600.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	89,367,000.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>7,921,280.00</b>
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,921,280.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шарга сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэнханд гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Шарга сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 03/76 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шарга сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн чиг үүргийг хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг дээшлүүлэх, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх ойрын бодлогыг зөв зохистой тодорхойлох иргэдийн ашгийг хамгаалан, сайн сайхан амьдрах орчин бүрдүүлэх хүний хөгжлийг бүх талаар хангах гэсэн эрхэм зорилготой.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шарга сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 2,040.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 40.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 32.0 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга**

Шарга сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7 хувиар буюу 273.6 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 141.8 сая төгрөг болж 43.4 сая төгрөгөөр өссөн нь СХС-гийн авлага барагдан орж ирсэн, ОНХС-гийн төлөвлөсөн ажлууд хийгдээгүйтэй холбоотой.

Авлага дансны үлдэгдэл 373.0 сая төгрөг болж 187.3 сая төгрөгөөр өссөн нь ЭМТ-ийн ЭМДСангаас авах авлага 200.7 сая төгрөгийн авлага нэмэгдсэнтэй холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 211.4 сая төгрөг болж 10.4 сая төгрөгөөр өссөн нь ковид цар тахалтай холбоотойгоор ЭМТ дээр эм боох материал, аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 348.8 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 159.0 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 496.0 сая төгрөгийн материалыг зарцуулж, 0.4 сая төгрөгийн материалыг шилжүүлж, 160 сая төгрөгийг акталж устгажээ. Оны эцэст 311.4 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,707.2 сая төгрөг болж 51.5 сая төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалжээ. Тайлант онд 25.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж устгасан байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 30.7 сая төгрөг болж 26.1 сая төгрөгөөр өссөн нь өмнөх оны 4.6 сая төгрөгийн өглөг барагдаж, шинээр ЭМТ дээр 30.7 сая төгрөгийн санхүүжилт илүү өгснийг өглөгөөр тусгасан байна. Он дамнасан 2.0 сая төгрөгийн өглөг ОНХС дээр бүртгэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,402.7 сая төгрөг болж 163.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 7 хувиар буюу 211.2 сая төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого буурсантай холбоотой байна

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 2,073.9 сая төгрөг болсон байна.

### **3.5.1 Орлогын данс**

Тайлант онд 54.3 сая төгрөгийн татварын орлого, 348.7 сая төгрөгийн татварын бус орлого, 2,846.4 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 3,249.5 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

### **3.5.2 Зардлын данс**

Тайлант онд 3,015.9 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал, 69.8 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардал хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

### **3.5.3 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт**

Шарга сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны "Сумын 2021 оны төсөв тодотгон батлах тухай" 08 дугаар тогтоолд зааснаар сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 41.2 сая төгрөгийн татварын 4.2 сая төгрөгийн татварын бус нийт 45.4 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 59.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 134 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг төлөвлөснөөс газрын төлбөрийн орлогыг 0.5 сая төгрөгөөр, бууны албан татварыг 0.08 сая төгрөгөөр тасарсан. Аудитаар татварын бааз суурийг хамруулж үзээгүй тул орлого тасарсан үндэслэлийг тодорхойлох боломжгүй байлаа

Орлогын гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад өндөр дүнгээр нэмэгдсэн татварын болон татварын бус орлогын төрөл байхгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Шарга сумын төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төслийг нэгтгэн гараагүй байна.

Сумын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 08 дугаар тогтоолоор 697.7 сая төгрөгийг сумын төсвөөс 2021 оны төсвийн жилд зарцуулахаар баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан төгрөгийн төсөв батлагдсанаас 2,369.3 сая төгрөгийг урсгал зардалд, 247.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх зээлд 151.5 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,183.2 сая төгрөгийг улсын төсвөөс буюу тусгай зориулалтын шилжүүлгээс, 697.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 97.3 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос 19.5 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн авсан. ЭМДСангаас 10.9 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус дутуу авсан байна. СХС-гийн орлогын төлөвлөгөө төлөвлөснөөс 29.2 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 105.8 сая төгрөг бүрдүүлж 8.6 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,915.3 сая төгрөг буюу 96 хувьтай байгаа нь зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд

- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 33.6 сая төгрөг
- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөнөөс 88.8 сая төгрөг
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 1.8 сая төгрөг
- Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 89.4 сая төгрөг нийт 213.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс нэмэгдэл урамшилд 32.0 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 3.5 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 15.9 сая төгрөг, норматив зардалд 39.5 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 14.3 сая төгрөг, томилолтын зардалд 0.8 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 42.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 22.1 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 34.7 сая төгрөг нийт 205.6 сая төгрөгийг зарцуулж, ЭМТ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 1.4 сая төгрөгийн, ЗДТГ-ын нэмэлт дансанд 6.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

ТТЗ: Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 36 мэдээллийг “Шарга сумын Засаг дарга” цэсэнд ил тод бүрэн байршуулсан байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Шарга сумын ИТХ нь тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 20 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Шарга сумын Соёлын төв нь тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 20 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Шарга сумын ИТХ нь тайлант онд 0.2 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28.2, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалтуудтай заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд :

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 28.5 сая төгрөгийн зөрчил илэрч, 1.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 27.2 сая төгрөгийн 3 заалт албан шаардлага, 1 заалт зөвлөмж хүргүүлсэн бөгөөд албан шаардлагын хэрэгжилтийг хангуулсан бөгөөд зөвлөмж хэрэгжилтийн шатандаа байна.

#### Харьяа нэгж байгууллагын тухайд:

Өмнөх 2020 оны СТА-аар сумын ИТХ-д 2 заалт албан шаардлага, Соёлын төвд 3 заалт албан шаардлага, ОНХС-гийн санхүүгийн тайлангийн түүврийн аудитаар 5 заалт албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Өмнөх 2020 оны ЭМТ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар 1.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг төлүүлээгүй, хэрэгжилтийг хангуулаагүй байна. Тус байгууллагын удирдлага .. удаа солигдсон байна.

## Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа ТТЗ-ийн аудитаар орон нутгийн орлого, татварын тодорхойлолт, өмнөх шийдвэрийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

Дараа жилийн түүвэрт хамрагдах нэгж байгууллагын аудитаар цалин, бараа материалын тайлангийн зарцуулалт, төсвийн хэмнэлтийн горимыг хэрхэн хэрэгжүүлж ажилласныг шалгах нь зүйтэй.

## 4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 3 төсөл сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллага, 1 санд дүгнэлт гаргаж, 2 байгууллага, 2 сангийн ажил гүйлгээг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Зөрчилгүй" 3 "Хязгаарлалттай" 2 дүгнэлт өгсөн байна.

### Дүгнэлт гарсан нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг аудитын дүгнэлт гарсан нэгж байгууллагуудад нийт 479.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 204.6 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 21.6 сая зөрчилд төлбөрийн акт тогтоож, 253.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

### Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 9.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 6.8 сая төгрөгийн зөрчилд 6 заалт албан шаардлага хүргүүлээ.

#### 4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Шарга сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар залруулга гараагүй.

#### 4.2 Төвлөрүүлэн захирагчийн Төлбөрийн акт

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хувьд:

- Засгийн газраас хөнгөлөлттэй олгосон усны төлбөр 2.5 сая төгрөгийг авлага тусгаагүй, тооцоо нийлээгүй нэхэмжлэн авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Түүвэрт хамрагдсан байгууллагын хувьд:

- Төлбөрийн акт тогтоогоогүй

#### 4.3 Төвлөрүүлэн захирагчийн Албан шаардлага

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хувьд:

- Газрын төлбөрийн орлогыг 0.5 сая төгрөгөөр, бууны албан татварыг 0.08 сая төгрөгөөр тасарсан нь Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 08 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Хаан банкинд тус сумын ЗДТГ нь 5331064213, ЭМТ нь 5331066946 тоот данстай байгаа нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4-т Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бичгээр ирүүлсэн зөвшөөрөлгүйгээр банк аливаа төсвийн байгууллагад данс нээхийг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### **Түүвэрт хамрагдсан байгууллагын хувьд:**

Шарга сумын ИТХ:

- Татварын тодорхойлолтоор 6.2 сая төгрөгийн илүү төлөлттэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Тайлант онд 0.2 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн нь Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Батлагдсан төсвийн зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын .. "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга

хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шарга сумын Соёлын төв:

- Батлагдсан төсвийн зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын .. "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Төвлөрүүлэн захирагчийн Зөвлөмж

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар зөвлөмж өгөөгүй.

#### 5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/							
				Залруулга		Үүнээс				Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага		Тоо
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>											
ТТЗ											
	Шарга сумын ТТЗ	3	3.0	0	0	1	2.5	2	0.5	0	0
Түүвэрт хамрагдсан байгууллага											
	Соёлын төв	1	0	0	0	0	0	1	0	0	0
	ИТХ	2	6.3	0	0	0	0	2	6.3	0	0
	<b>Дүн</b>	<b>6</b>	<b>9.3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>2.5</b>	<b>5</b>	<b>6.8</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>											
	ТТЗ	0	0	0	0	0	0	0	0	0	0
	<b>Дүн</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
	Соёлын төв	0	0	0	0	0	0	0	0	0	0
	ИТХ	1	0.2	0	0	0	0	1	0.2	0	0
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0.2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0.2</b>	<b>0</b>	<b>0</b>
	<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>9.5</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>2.5</b>	<b>6</b>	<b>7.0</b>	<b>0</b>	<b>0</b>